

Өмнөговь аймгийн хүн амын эрүүл мэнд, эмнэлгийн тусламж

үйлчилгээний товч мэдээлэл

/2019 оны 3 сарын байдлаар/

	Үзүүлэлт	<u>БОЭТ</u>	Сумдын эмнэлэг	Өрхийн эмнэлэг	Хувийн эмнэлэг	Цэргийн анги	Нийт аймгийн дүн
1	Нийт үзлэг	29662	29813	19868	9669	975	89987
2	Урьдчилан сэргийлэх үзлэг	11438	8719	5855	614	840	27466
3	Идэвхтэй хяналтын үзлэг	3344	5840	4591	626		14401
4	Бүртгэгдэж эмчлэгдсэн өвчлөл	7617	7011	4439	2272	118	2157
5	Нийт төрөлт	289	71				360
6	Хэвтэн эмчлүүлэгчид	2107	1332		498	10	3947
7	Нас баралт	9	44	17			70

1. Улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд нийт 89987 хүнд үзлэг шинжилгээ хийсний 46.5%-д нь урьдчилан сэргийлэх болон идэвхтэй хяналт тандалтын үзлэг хийгдсэн байна.
2. Ортой эмнэлгүүдэд нийт 3947 хүнийг 26585 ор хоногоор хэвтүүлэн эмчилсэн нь нэг хүн дунджаар 6.7 хоног хэвтэн эмчлүүлсэн байна.
3. 3 сарын байдлаар 21457 халдварт бус өвчлөл шинээр бүртгэгдэж эмчлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 4879 тохиолдлоор өссөн байна.
4. Эхний 3 сарын байдлаар 300 хүн осол гэмтэлд өртсөний улмаас тусламж авсан ба осол гэмтлээр 12 хүн нас барсан нь өнгөрсөн оноос өвчлөл 20 тохиолдлоор, осол гэмтлийн нас баралт 4-р буурсан байна. Осол гэмтлээр нас барагсдын 41,6% /5/нь амиа хорлож/Гт-1,Мн-1,Хх-1,Хб-1,Эу-1/ 25%/3/нь зам тээврийн осол,/Но-1,Хү-1,Эх-1/, 25%/3/ нь ахуйн ослоор/хөлдсөн-Сэ,Хб-1,архины хордлого-Гт-1/ 8,3%/1/бусдад хорлогдсон-/Но-1/ тус тус эндсэн байна. Осол гэмтлээр нас барагсадын 91,6% нь эрэгтэй хүмүүс эндсэн байна. Мөн ослоор эндэгсдийн 58,3% нь эмнэлгийн ямар нэг тусламж авч чадаагүйн дээр эмнэлэгт нас барсан 5 хүн нь /Хб-өөрийгөө буудсан-1, хөлдсөн-1, зам тээврийн осол-2,бусдад хорлогдсон-1/хүнд гэмтлийн улмаас хоног болоогүй нас барсан байна. /Нийт осол гэмтлийн нас баралт-Гт-2/амиа хорлосон-1,хөлдсөн-1/,Мн-амиа хорлосон-1,Но-зам тээврийн осол-1,Сэ-хөлдсөн-1,Хх-амиа хорлосон-1,Хб-2/ амиа хорлосон-1,хөлдсөн-1/,Хү-зам тээврийн осол-1,Эу-амиа хорлосон-1/
5. Оны гарсаар 70 хүн нас барсан ба нийт нас барсан хүний 17,1% нь осол гэмтлээр, 27,1% хорт хавдраар,8,5% зүрхний шигдээс, тархинд цус харвалт/Но-1,Хх-2,Шб-2,Өо-1/ зэрэг сэргийлж болох эндэгдэлээр, 6,2% /Хб-1,БОЭТ-2//нь нярай үеийн эмгэгийн улмаас нас барсан байна.

6. Нялхсын эндэгдлийн 4 /Хб-3,Цц-1/тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй адил ба 1000 амьд төрөлтөд 11,1 байна.
7. Түргэн тусламжийн 3763 дуудлагад явж үйлчилсний 556/14.7%/ нь алсын дуудлага, 165/4,3%/ нь осол гэмтлийн яаралтай дуудлага байсан байна. Нийт дуудлагын 95,7% -д 0-20 минутны дотор гарч үйлчилсэн байна .
8. 3 сард 4003 хүүхдийг идэвхтэй хянаж, хооллолт өсөлт хөгжилтийн байдлыг үнэлэн зөвлөгөө дэмжлэг үзүүлсэн нь хяналтад хамрагдвал зохих хүүхдийн 41,2% эзэлж байгаа нь хангалтгүй байна. Хяналтанд хамрагдсан хүүхдүүдээс 9 хүүхэд жингийн алдагдалтай байгаа нь нийт хүүхдийн 0,2%-г эзэлж байна.
9. Нийт 360 эх төрж 359 хүүхэд мэндэлсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад 3 төрөлтөөр хүн амын төрөлт буурсан байна. Нийт төрсөн хүүхдийн хүйсийн харьцаа 1,1:1 байгаа ба эрэгтэй хүйс давамгайлж байна. Нийт төрөлтийн 7,2% охидын төрөлт эзэлж байгаа нь анхаарал татаж байгаа үзүүлэлт байна/Бо-1,Бу-2,Гт-3,Мн-2,Но-1,Сэ-1,Хб-1,Хх-2,Хү-1,Цц-2,Шб-1,Өо-6,Эх-3/ .
10. 3 сарын байдлаар 122 эх үр хөндүүлж 1000 амьд төрөлтөд 339,8 байгаа нь өнгөрсөн оноос 1,7% буурсан үзүүлэлт байна.Өсвөр насны охидын үр хөндөлт 6,5%/Бд-1,Бу-1,Но-1,Хб-2,Шб-1,Өо-1,Б/г-1/ байна.
11. Он гараад 104 халдварт өвчин бүртгэж эмчилсэн нь өнгөрсөн оноос 90 тохиолдлоор буурсан байна. Нийт халдварт өвчний 26%-г салхинцэцэг, 6,7%-г улаанэсэргэнэ өвчин, 52%-г БЗДХ өвчин тус тус эзэлж байна.
12. ЭЭСангуудад нийт 4822 жор ирсний 49,7%/2401/нь ЭМДаатгалын, 0,1% /7/ мансууруулах эмийн, 2.3% /113/ сэтгэц нөлөөт эмийн, 47,7% /2301/ нь энгийн эмийн жор байсан ба 0,6% /29/нь алдаатай жор байсан байна. Зайлшгүй шаардлагатай эмийн хангалт дундажаар 82,2% байна.
13. БОЭТөвд 9 эндэгдэл тохиолдож 2 эндэгдэлийг онош тодорхой, өндөр настан, ар гэрийн хүсэлтээр гэсэн шалтгаанаар задлан шинжилгээнд хамруулаагүй ба задлан шинжилгээний хувь 77,7% тай байна. Үндсэн оношийн зөрөө 0%.

Мэдээлэл бэлтгэсэн: ЭМГ-н статистикч Б Мидэрсүрэн , Д. Гантогтох